



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/540

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн захирамжлах нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжлийг сурталчлан таниулах, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт инновац хийх чадвартай иргэдийг ахлах ангиас нь бэлтгэх, чиглүүлэх зорилготой "ХУРДАН СУР 2025" баруун бүсийн ахлах ангийн сурагчдын харилцаа холбоо, мэдээллийн технологийн тэмцээнд оролцоход зарцуулагдах унаа шатахууны зардал 942,480 (есөн зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун наяд) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)- д зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналь-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

